

ШХАБ: ӨРГӨЖИХ ҮҮ, УНТРАХ УУ?

*К.Дэмбэрэл**

Төв Азид аюулгүй байдал хангаж хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго бүхий байгууллага болох ШХАБ-ын талаар, нэн ялангуяа түүний үүсэл, чиглэл, үйл ажиллагааны талаар урьд нь “Төв Азийн геополитик” (УБ., 2005) номонд дэлгэрэнгүй бичигдсэн тул нурших шаардлагагүй гэж үзлээ. Ингээд ШХАБ нь хамтын ажиллагааны “амьд” механизм байж чадах аль эсвэл “цоожтой хайрцаг” хэвээр байх эсэх талаар өгүүлэхийг зорилоо.

ШХАБ бол хүн ам, газар нутгийн хэмжээгээрээ бол дэлхийн талыг эзэлсэн асар том бүтэц. Тиймээс энэхүү “аварга” бүтцийг “амьд” механизм болгох нь төвөгтэй бөгөөд эрсдэлтэй урт хугацааны ажил байх нь дамжиггүй. Анх хил орчмын асуудлаар ажлаа эхэлсэн ч олоо эдийн засгийн хамтын ажиллагааны болон алан хядлага, салан тусгаарлах үйл ажиллагааны эсрэг чиглэсэн хамтын ажиллагааны байгууллага болон хувирсан. Ерөнхийдөө бол ШХАБ нь хуучин Дундад Ази буюу одоогийн Төв Азийн бүс нутагт Орос, Хятадын ойлголцлыг зохицуулах механизм хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

ОХУ, БНХАУ-ын хувьд олон тооны оролцогч ШХАБ-д хамрагдахыг нэг их хүсэхгүй байгаа ба нэн ялангуяа, хүчтэй субъект орж ирвэл тэдний нөлөө буурах нь ойлгомжтой. Харин ОХУ-ын хувьд Төв Азид явуулах бодлогын үндэс суурь нь ШХАБ бус ТУХН, ОДКБ зэрэг бүтцүүд байх нь ойлгомжтой. БНХАУ-ын хувьд Шинжаан-Уйгурын автономит район нь Төв Азийн улсуудтай шууд хиллэдэг, үндэсний цөөнх аж төрдөг, мусульман шашинтай, салан тусгаарлах үзэл нэвт шингэсэн, “шүдний өвчин” болсон хэсэг. Тиймээс Төв Азийн улсуудын тогтвортой хөгжил БНХАУ-ын хувьд чухал зүйл. Энэ утгаараа Хятад улс бүс нутагт чиглэсэн “давшингүй” үйл ажиллагаа явуулж байгаа. Дараагийн нэг зүйл бол бүс нутгийн эрчим хүчний эх үүсвэрт өөрийн гэсэн хяналтыг тогтоох нь юу юунаас илүү чухал болоод байгаа. Хуучин ЗХУ-ын нөлөөнд байсан бүс нутагт Хятадын зүгээс “яаралтай” довтлох нь тийм ч хүсэх зүйл биш учраас “алгуур нэвчих” бодлогоо явуулж байгаа.

ШХАБ-ын язгуур зорилго болох тогтвортой байдал, энх тайван, хил орчмын бүсэд сайн хөршийн харилцааг дэмжих чиглэлд анхаарлаа түлхүү хандуулахыг судлаачид тэмдэглэж байгаа. Өөрөөр хэлбэл, ШХАБ нь “чадах ажлаа” илүү хийхийг хүсч байна. Зөвхөн энэ нөхцөлд л түүний “амьдралын баталгаа” бий болно. Эсрэг нөхцөлд 2 дахь ТУХН болж хувирна хэмээн судлаачид бичсээр байгаа. ШХАБ-ын зорилго, үйл ажиллагааны тодорхойгүй байдал нь түүнийг “Дорно дахины НАТО”, “Цөмийн зэвсэгтэй ОПЕК” гэсэн хүсэшгүй нэрийг авахад хүргээд байна. Тиймээс анхны тавьсан зорилго чиглэлдээ анхаарлаа хандуулан дээрхи сөрөг нэр томъёоноос салах хэрэгтэй байгаа.

ШХАБ-ын өргөжин тэлэх үйл явцын векторыг зүүн, урагш гэсэн чиглэлд бодит ажил хэрэг болгохоос гадна, “өрнөдийн” гэсэн тодотголтой улсуудыг

* К.Дэмбэрэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

нээлттэй оруулах нь түүний “насыг” уртасгах боломжтой. Япон улс ШХАБ-д орох хамгийн боломжийн улс гэдгээр өөрийгөө тодруулсан байгаа. АНУ, ЕХ-г бодвол хүний эрхийн асуудлаар хамаагүй их дуугардаггүй, Азийн бурхны шашинт, Төв Азид тогтсон харилцаатай улсын хувиар Японыг оруулж болох талаар судлаачид бичиж байгаа. Японыг оруулснаар ШХАБ-ын нэр хүнд, нээлттэй байдал улам л бэхжих боломжтой. Ингэснээр зарим нэг нэр томъёоноосоо бүрэн хагацах боломжтой болно. Тэрээр Японы хувьд ажиглагч нартай ч сайн харилцаатай явж ирсэн. Сүүлийн үед “Төв Ази+Япон” форумыг амжилттай зохион байгуулж байгаа. Япон нь Энэтхэг, Пакистанд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байгаа. Энд үйл явцад ОХУ, Хятадын зүгээс л саад хийхгүй тохиолдолд Япон элсэх бүрэн боломжтой улс.

Японд ажиглагчийн статус олгож, Энэтхэгийг жинхэнэ гишүүн болгосноор ШХАБ-ын үйл ажиллагаа улам эрчимтэй болж эдийн засгийн үр өгөөж нэмэгдэх боломжтой. Монгол Улсын хувьд Орос, Хятад хоёроос Монголын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц томоохон төслийг хамтран хэрэгжүүлэх нөхцөлд гишүүнээр орох нь зүйтэй.

Цэрэг, батлан хамгаалах болон эрчим хүчний салбарт ШХАБ нь хамгийн нэр нөлөө бүхий олон улсын хамтын нийгэмлэг болох боломжтой. Энэ улсаараа зарим улсын сонирхолд сөрөг нөлөө үзүүлж буй тал бий.¹

Төв Азийн эрчим хүчний эх үүсвэрийг дамжуулах хоолойн систем, эрчим хүчний эх үүсвэрийн нэгдсэн биржийг ШХАБ-ын хүрээнд байгуулах нь уг байгууллагын гишүүн орнуудын нийтлэг эрх ашиг байх болно. Үүнийг хамгийн идэвхтэй дэмжигч нь Казахстан улс. Эдийн засгийн томоохон төслүүдийг ШХАБ-ын хүрээнд хэрэгжүүлэх нь гишүүн “жижиг улсуудад” нэн чухал байгаа.

Туркменийг ШХАБ-д татаж оруулах нь ОХУ-д нэлээн ашигтай зүйл болно. Ингэснээр эрчим хүчний бүлэглэлд ОХУ-ын нөлөө нэмэгдэн гол тоглогчийн статус баталгаатай болно. Иран, Пакистантай нийтлэг ойлголцолд хүрсэн тохиолдолд хийн дамжуулах хоолойг дэлхийн аль өншөг булан руу чиглүүлэх нэгдсэн найдвартай системтэй болох боломжтой.

ШХАБ-г хамтын ажиллагааны механизм болгоод авах нь ОХУ-аас илүүтэйгээр БНХАУ-д хүртээмжтэй байгаа. Энэтхэг, Ираныг оруулснаар ШХАБ нь НАТО, Өрнөдийн эсрэг зогсох хүчтэй механизм болж чадна гэсэн ойлголт ч байгаа.

АНУ-ын хувьд Төв Азийг өөрийн сонирхлын бүс хэмээн зарлахдаа энд ОХУ-ын цэрэг-улс төрийн болон эдийн засгийн нөлөө суларч байгаа, Хятадын өсөн нэмэгдэх хүчийг тогтоон барих тохиромжтой геостратегийн хувьд ашигтай бүс нутаг² хэмээн тодорхойлсон. Энэ нь 2006 оны Үндэсний аюулгүй байдлын стратегийн баримт бичигт тусгалаа олсон.

ШХАБ-ын хэтийн төлвийн талаархи вээрсүүд

ОХУ-ын хувьд ШХАБ-аар мэргэжсэн хүмүүсийн нэг болох А.Лукиний үзэж буйгаар ШХАБ-ын цаашдын хөгжлийг аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаа, соёл, боловсрол, спортын хамтын ажиллагаа гэсэн 3 чиглэлд хөгжүүлэх нь илүү шаардлагатай байгаа. Гэхдээ энэ байгууллага аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагааг маш хүчтэй явуулж байгаа

төдийгүй цэрэг, батлан хамгаалахын салбарт илүү ойр дотно харилцаатай байгаа нь уг байгууллагын Хартийг зөрчсөн хэрэг болж байгаа юм хэмээн зэмлэсэн удаа бий. Оросууд гишүүнчлэлийн хувьд Белорус, Шри-Ланк хоёрыг байж болох субъектын хэмжээнд тооцож байгаа. 2005 оноос буюу ШХАБ-ын зүгээс Афганистаны асуудлаар тууштай хандаж эхэлсэн үеэс л НАТО түүнтэй харилцах харилцаагаа эхэлсэн. Төв Азид ОХУ, БНХАУ нь Афганистаны асуудлаар байр сууриа нэгтгэх нь зүйтэй.

Эдийн засгийн хамтын ажиллагаанд ахиц гарахгүй байгаа бөгөөд олон талт эдийн засгийн хамтын ажиллагаа бараг байхгүй байгаа. Төв Азийг дайрсан ОХУ-аас Хятад руу чиглэсэн 2 замын төслийг эс тооцвол тодорхой төслүүд өнөө хүртэл хэрэгжээгүй л байна.

Гол шалтгаан нь Орос, Хятадын зүгээс аливаа асуудалд өөр өөрсдийн сонирхлоор хандаж байгаа явдал. Хятадын хувьд эдийн засгийн нээлттэй хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байгаа. ОХУ-ын Засгийн газар, тухайлбал, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам нь ШХАБ-ын гол зорилго нь аюулгүй байдлын хамтын ажиллагаа болохоос биш эдийн засгийн хамтын ажиллагаа биш гэж үздэг. Харин эдгээр яамдын зүгээс Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд явуулахыг хатуу тулгадаг. Эдгээр яамдын зүгээс төсвийн мөнгийг ОХУ-ын нутаг дэвсгэрээс гадуур зарцуулахыг хориглосон хуулийн хүрээнд л асуудлаа тавьж байгаа болов уу.

БНХАУ-аас ОХУ-д сууж байсан Элчин сайд Ли Фэнлиний үзэж буйгаар ШХАБ-тай холбоотой асуудлыг Орос, Хятадын хоорондын түншлэл, харилцан ойлголцлыг бэхжүүлэх болон дэлхийн улс төр, эдийн засгийн шинэ дэг журмыг бий болгох, энх тайван, аюулгүй байдлыг хангах чиглэлд стратегийн харилцааг бэхжүүлэх явдал аж. Ер нь ШХАБ бол “хүйтэн дайны” дараа бий болсон бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааны сэтгэлгээний үйл ажиллагааны шинэ хэлбэр хэмээн хятадууд үздэг.

ШХАБ-ын хүрээнд буй төвөгтэй асуудлууд: Хөгжлийн ялгаа, Казах-Узбекийн зөрчилдөөн, интеграцийг өөр өөрсдийн сонирхолд чиглүүлж байгаа, аюулгүй байдлын үйл ажиллагааг өөр өөр өнцгөөс харж байгаа, Төв Азид буй бусад байгууллагуудтай үйл ажиллагаа нь зохицуулагдаагүй, бүс нутгийн талаархи Орос, Хятадын сонирхлын зөрчилдөөн, ШХАБ-ын зүгээс АНУ, ЕХ-той тодорхой бус харилцаатай байгаа байдал.

ОХУ-ын хувьд Төв Азийг өөрийн онцгой сонирхлын бүс гэсэн сэтгэлгээнээсээ салахгүй байгаа буюу түүний хувьд Төв Азийн бүсэд зохих нөлөөтэй байх нэмэлт суваг хэмээн Казахстан судлаачдын бичсэнийг Хятадын тал дэмжсэн байсан.

ШХАБ-д бүтээлч сэтгэлгээ, хамтын ажиллагааны шинэ загварыг эрэн хайх нь нэн чухал болоод байна. Хятадуудын үзэж буйгаар бол ТУХН-ийн хүрээнд улс орнуудын нэгдсэн байдлыг “эмгэнэлт үйл явдал” хэмээн үздэг. Төв Ази нь өөрийн газар зүйн байрлал, геополитикийн ач холбогдлын хувьд их гүрнүүдийн глобал анхаарлын төвд байгаа. ШХАБ нь тодорхой чиглэлд бүс нутгийн бус улс орнуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэхийг

хятадын тал дэмждэг. Түүнчлэн ШХАБ-ын орнууд бие даан 2 талын хамтын ажиллагааг өргөжүүлэхийг ч дэмждэг ба энэ нь Орос, Хятадаас хамааралтай гэсэн хардлагыг арилгах ач холбогдолтой хэмээн хятадууд үздэг. ШХАБ-ыг илүү нэгдмэл, хүчирхэг болгох хамтын ажиллагааны тийм хэлбэрийн төлөө байгаа гэдгээ ч хятадууд илэрхий гаргаж байгаа. ШХАБ-ын эрүүл, саруул хөгжлийн баталгаа нь Орос, Хятадын нягт хамтын ажиллагаа хэмээн талууд үздэг.

Бүс нутгийн хөгжлийн асуудлаар талуудын хариуцлага, сонирхлыг тодорхой байлгах тийм нээлттэй яриаг бий болгох хэрэгтэй байгаа. Стратегийн болон үндэсний сонирхол үндсэндээ 2 улсын хувьд нийлж байгаа. Аливаа асуудлаар ШХАБ-ын хүрээнд яриа, хэлэлцээрийг өргөжүүлэх хэрэгтэй. Хятадууд Оросын хуучин нөлөө Төв Азид хадгалагдах хүсэл эрмэлзлийг ойлгож байгаа. Тиймээс Хятадын байр суурийг тодорхой болгох ёстой.

Төв Азийн аюулгүй байдлыг хангахад ШХАБ ямар үүрэгтэй байхыг илүү тодруулахыг хятадын тал хүсээд байгаа. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлыг хангахад хэдийгээр ШХАБ, ОДКБ хоёрын хооронд хэлэлцээр бий ч үүрэг ролийг зааглах буюу хаана, нэгдэж байгаа, хаана хуваагдаж буйг ялгаж салгахыг хятадын тал хүсээд байгаа.

БНХАУ-ын төрийн албаны зарим хүмүүсийн үзэж буйгаар НҮБ, G-8, G-20 хүрээнд үр ашиггүй байгаа хэмээн шүүмжилдэг. Тиймээс ирээдүйн дэлхийн архитектурыг зохион бүтээгч институтыг бүтээлч байлгах гэдэг талаас нь ШХАБ-ыг ямар байлгах талаар өргөн хэлэлцүүлэг хийж байна.

ШХАБ-ын асуудлаар академик Ли Жинжэ дараахи байдлаар байр сууриа илэрхийлсэн байдаг. Үүнд: “Хүйтэн дайн” дараа бий болсон гол асуудал бол дэлхийн хэмжээний аюулгүй байдлын бүтэц, шинэ дэг журмын асуудал байлаа. Хоёр үндсэн зам байсан ба нэг нь урьдын адил хоёр бүлэглэл болчихоод хоорондоо сөргөлдөх, өрсөлдөх, тэмцэлдэх, нөгөө нь аюулгүй байдлын шинэ сэтгэлгээ бүхий шинэ бүтэц, дэг журам, хэм хэмжээ бүхий хөгжлийн зам байлаа. Орос, Хятадын аль алины сонирхол энэхүү шинэ маягийн бүтцийг илүүд үзэж байгаа. Чухамхүү, ШХАБ нь энэ үзэл санааны анхны илрэл байсан гэж үзэж болно. Уг байгууллагын үзэл санааны үндсэн зарчмууд болох харилцан итгэлцэл, харилцан ашигтай байх, зөвшилцөх, олон төрлийн соёлын хэв шинжийг хүндэтгэн хөгжүүлэх гэсэн зүйлүүд нь гишүүн орнуудад таалагдсан. ШХАБ нь гишүүн орнуудыг үзэл суртал, нийгмийн байгууллын талаас нь хөндөөгүй ба зөвхөн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмаа баримталж байгаа.

АНУ-ын стратегийн хувьд Төв Азийг түүний дэлхийн бодлогын нэг гол хэсэг хэмээн үздэг ба “Том Төв Ази” гэсэн томъёололд Дундад Азийн таван улс дээр Пакистан, Энэтхэг, Афганистаныг оруулсан байдлаар авч үздэг.

Өнөөгийн олон улсын хэв маяг буюу дэлхийн өнөөгийн дэг журамд ОХУ, БНХАУ хоёр сэтгэл хангалуун байж чадахгүй байгаа. Хэтэрхий өрнөд давамгайлсан нөхцөл байдлыг саармагжуулах бодлого бол тэдний хувьд шинэ дэг журмын төлөө гэсэн бодлоготой зэрэгцэн явагдаж байгаа. Тэгээд ч тоглоомын дүрмийг гаргахад Хятад, Оросын оролцоо байгаагүй. Тиймээс

өөрчлөхийн төлөө л байгаа. Тиймээс бид хамтарч /орос, хятад/ өөрсдөдөө тохирсон шинэ дэг журам боловсруулахад голлон оролцох ёстой байгаа хэмээн Хятадын элчин сайд асан Ли Фэнлинь өгүүлсэн.

Шинэ дэг журмын хувьд судлаачдын хэд хэдэн санааг энд өгүүлье. “Ардчиллын” бүлэглэл буюу АНУ тэргүүтэй /НАТО-г түшиглэсэн/ альянс нь өөртөө Япон, Австрали, Энэтхэгийг татах замаар хамгийн хүчтэй бүлэглэл үүсгэх боломжтой. Хятадуудын үзэж буйгаар энэ нь эхний ээлжинд БНХАУ-ын эсрэг чиглэсэн бүлэглэл байх нь гарцаагүй болно. Ийм нөхцөл байдалд Хятадын хувьд түүнд зохиож амьдрах асуудал яригдах талтай.

Дараагийн вээрс бол АНУ, БНХАУ гэсэн G-2 –г үүсгэх явдал.

Дараагийн вээрс бол хамгийн муу хувилбар болох БНХАУ оройлж эхлэх үйл явц.

Тэргүүлэх гүрнүүдийн хамтын манлайлал буюу G-20 маягаар шинэ дэг журамд хүрэх асуудал. Чухам энэ үед л ШХАБ-д цаашид “аж төрөх” магадлал байгаа гэсэн үзэл ч бий. Оросуудын тэргүүлэх улс төрчид ч ШХАБ-г “хэрэгтэй, ашигтай” байгууллага хэмээн хүлээн зөвшөөрч байгаа. Ирээдүйн дэлхийн архитектурт ШХАБ ямар байр суурьтай байх талаар судлаачдын байр суурийг сонирхвол: ШХАБ-д Орос, Хятадын байр голлодог гэдэг нь илэрхий. Харин тэнд тэдгээрийн сонирхол зөрчилтэй байгаа нь бүр илэрхий. Энэ нь уг байгууллагыг дэлхийн бодлогод тэргүүлэх байр суурийг эзлэхэд сөргөөр нөлөөлж байгаа гэдгийг ч хоёр зөвшөөрч байгаа. Чухам юун дээр зөрчилдөж байгаа талаар авч үзвэл. Оросууд ШХАБ-г зохих чиглэлд нь хурдан оруулахын төлөө байгаа бол хятадууд нэг их яарахгүй л байгаа. Энэ талаараа санаа нэгдээгүй байгаа. Түүнчлэн хятадууд ШХАБ-г эдийн засгийн аюулгүй байдлыг хангах шинжтэй байгууллага байлгахыг хүсч байгаа бол оросууд аюулгүй байдлыг хангах чиглэлд нь түлхүү ажиллуулахыг хүсч байгаа.

Хэрвээ бие биенээ хардаж байгаа тохиолдолд НАТО-гоос сургамж авч болно. Тэнд АНУ давамгайлдаг ч үүрэг, ролийг нэлээн тодруулсан байдаг. Энд Хятад эдийн засгийн хүчээр түрүү бариад, Оросууд цэрэг-техникээр түрүү бариад амжилт олох нь ямар л бол. Тиймээс Орос, Хятадын тохироо юу юунаас илүү чухал бөгөөд ШХАБ-ын цаашдын үйл ажиллагаанд түлхэл болох юм. Энд бага зэргийн харилцан буулт яах аргагүй чухал.

Хятадуудын хувьд АНУ-г ШХАБ-д орж ирэхийг дэмжихгүй байгаа бол, оросууд хэдийгээр америкчуудад сайнгүй ч энэ байгууллагад хятадтай хоёулаа байхыг ч хүсэхгүй байгаа. Өөрөөр хэлбэл, ШХАБ-д гуравлагч гүрний оролцооны талаар нэгдсэн ойлголт хоёр улсад алга байгаа. Энэ утгаараа ШХАБ тийм үр ашигтай механизм болж өгөхгүй байгаа. Жишээ нь гэхэд л Афганистаны асуудлаар тодорхой алхам хийгээгүй байна. НАТО гарлаа гэхэд бид яах ёстойгоо одоо ч тодорхойлоогүй байна. Албан бусаар АНУ-тай гурван талт хамтын ажиллагааг хөгжүүлэх санал гарч байсан ба Орост бол нэлээн дэмжлэг хүлээж байгаа.

Оросуудын үзэж буйгаар өнөөгийн дэлхий дахин аюулгүй байдлын хувьд улам бүр эзгүйрэн хоосорч буй орчин руу орж байна. Учир нь АНУ урьдын адил хэмжээнд үүргээ гүйцэтгэсээр, Европ хариуцлагаас мултарч

байгаа, Хятад өсөн дэвшиж байгаа, Бразил, Энэтхэг хариуцлага үүрэх хараахан болоогүй байгаа гэсэн нэгэн ёсны эзгүйдэл бий болоод байгаа аж. Нэн ялангуяа, энэ байдал Персийн булан, Том Төв Азид улам ч илэрхий болж байгаа гэнэ. Өөрөөр хэлбэл энэ бүс нутаг аюулгүй байдал талаасаа муудсаар байгаа гэсэн үг. Энд бол бүр бие биендээ итгэхээ больсон, зэвсэглэлээр хөөцөлдөх асуудал, нэн ялангуяа цөмийн зэвсэгээр хөөцөлдөх байдал илт нэмэгдэж байгаа.

Энэ талаар АНУ-тай зохих бэлтгэлтэйгээр яриа хэлэлцээр эхлүүлэхийг ОХУ хүсэж байгаа ба Европтой энэ талаар ямар ч үр дүнд хүрэхгүй байгаа. Учир нь Европ шууд татгалзаж байгаа буюу томоохон асуудлаар ярихыг хүсэхгүй байна. Европчууд бүх хариуцлагыг Америкчууд руу тохож байгаа. Хэдий тийм ч америкчууд ч бэлэн бус байгаа шүү дээ. Ийнхүү “ваакум” байгаа нөхцөлд аюулгүй байдал, хяналттай орчинг бий болгох гурван талын хамтын ажиллагаа зайлшгүй байгаа юм.

Оросуудын хувьд америкчуудад итгэх итгэл бүр наяд оныхоос буурсан хэдий ч харилцааг сайжруулах тал руу ажил явагдаж байгаа. Европчууд аюулгүй байдлаа АНУ-д, эдийн засгаа Хятадуудад даатгасан байдалтай байгаа нь оросуудын санаа зовоосон асуудал болоод байгаа. Афганистанаас НАТО гарсан үед биеэ авч явах асуудал чухал болоод байгаа. АНУ-ын хувьд Афган гол биш Иран чухал шүү дээ.

Хилийн маргаан нь Төв Азийн улс орнуудын төвөгтэй асуудлыг нэг мөн. Тэдгээр улсуудын хоорондын харилцаанд хагарал үүсгэж буй асуудлын нэг ч мөн. Байгалийн баялгаа дэлхийн зах зээлд гаргах тээврийн дэд бүтэц байхгүй байгаа нь тэдгээрийг хөрш ОХУ-аас хараат байх нэг нөхцөл болоод байгаа. Хүний нөөц арвин ч мэргэжилтэй боловсон хүчний асуудал оросууд дүрвэснээр эхэлсэн. Ундны усны хомсдол, үр шимтэй газар нэгж талбайд ногдох хүн амын нягтаршил зэрэг төвөгтэй асуудал байсаар байна.

Аюулгүй байдлыг хангах механизмын хэмжээнд ОДКБ /Туркменээс бусад түүний шүхэр дор байгаа/, эдийн засгийн интеграцийг хангах механизмын хэмжээнд ЕврАзЭС ажиллаж байгаа тул ШОС-ын хувьд энэ хэмжээнд хүрч ажиллахад нэлээн төвөгтэй болоод байна.³ Энэ нь ОХУ-ыг бүс нутагт тэргүүлэх үүрэг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж байна. Туркмен, Узбек, Казахстан байгалийн хийн илэрсэн нөөц нь дэлхийн илэрсэн нөөцийн 4,3%-ийг эзэлдэг ба 8 их наяд шоо м. хүрээд байна.

Төв Азид Оросын хуучин нөлөө сэргээхгүй байх, өөрийн нөлөөг бий болгох гэсэн АНУ-ын бодлого, хуучин нөлөөгөө чадвал 100 хувь сэргээх, үгүйдээ нөлөө алдахгүй байх гэсэн ОХУ-ын бодлогын зөрчилдөөн дундаас БНХАУ-ын өөрийн байр суурийг бэхжүүлэх гэсэн “мөлхөө” бодлого явуулах болсон.

ШХАБ дахь ОХУ, БНХАУ-ын сонирхол нь Төв Азид өөрсдийн байрыг бэхжүүлэх, хяналтыг нэмэгдүүлэх, тэнд АНУ-ын нөлөөг багасгах, АНД байр сууриа өргөжүүлэх стратегийн зорилго агуулж байгаа.

Төв Азид зөвхөн АНУ-аас гадна шинэ өрсөлдөгчид гарч байгаа нь Орос, Хятадын хувьд нэмэлт асуудал үүсгэж байгаа. Эдгээр улсуудад Турк, Иран, Энэтхэг, Пакистан, Япон зэрэг орнууд байгаа. Тухайлбал, Японы

хувьд 2004 онд “Төв Ази+Япон” гэсэн яриа хэлэлцээрийн механизмыг буй болгосон.

ШХАБ-ын үйл ажиллагааг тодорхой хэмжээнд зохицуулж байгаа нь ОХУ-ын зүгээс Төв Азид БНХАУ-ын нөлөөг гүнзгийрүүлэх үйл явцыг саармагжуулж байна. Гэхдээ аль алин өрсөлдөөнийг бус харилцан ашигтай хамтын ажиллагааг эхний ээлжинд өргөжүүлэх чин хүсэлтэй байгаа. Хэрвээ ямар нэгэн бүтцээр дамжуулан өөрийн эрх ашгийг илэрхий хамгаалж чадвал энэ нь тухайн улсын хувьд уг бүтцийг бүрэн дүүрэн ашиглаж буй механизм болж болох юм. ШХАБ-ын хувьд Орос, Хятад нь өөрсдийн эрх ашгийг бүрэн илэрхийлэх боломж гаргаж чадаагүй байгаа тул механизм хэмжээнд хүрээгүй хэмээн дүгнэх боломжтой.

Хятадын хувьд ШХАБ-ыг Төв Ази, АНД-н бүсийг холбосон тийм механизм болгож өөрийн байр суурийг энэ 2 том орон зайд бэхжүүлэх туйлын зорилго байгаа. Иран-ОХУ-МАГАТЭ-ШХАБ гэсэн хамтын ажиллагааны бүтэц бий болох нөхцөл ч бас бий. ШХАБ-ын хүрээнд бүс нутгийн “Эрчим хүчний клуб” байгуулах ажлыг санаачилсан бөгөөд энэ нь нэг талаас уг байгуулгын гишүүн эрчим хүчний эх үүсвэрийн томоохон гишүүн-нийлүүлэгч болох ОХУ, Казахстан, Узбекистан, Иран /Туркмен, Азербайжаныг хэтдээ хамруулах бүрэн боломжтой/, нөгөө талаас гишүүн - хэрэглэгч болох БНХАУ, Энэтхэг, Таджик, Кыргыз, Пакистан нар байж болох юм.⁴

Японы Хоккайдо их сургуулийн Слав судлалын төвийн судлаач Ивашита Акихирогийн “Төв Азийн геополитик: Японы байр суурь /ШХАБ: гурван төөрөгдөл ба Японы оролцоо/” номонд уг байгууллагыг “Америкийн эсрэг Орос-Хятадын альянс”, “ШХАБ-ын тусламжтайгаар Төв Азид ОХУ, БНХАУ-ын хяналт тогтоох механизм”, “ШХАБ шинэ гишүүд элсүүлснээр хүчирхэгжинэ” гэсэн томъёолол өгсөн байна. Өөрөөр хэлбэл, ШХАБ ийм 3 төөрөгдөл орчихоод байна гэсэн үг.

Дүгнэлт:

ОХУ, БНХАУ-ын харилцан тэншвэртэй харилцааны үед ШХАБ нь хамтын ажиллагааны механизм байх боломжтой бөгөөд тэдгээрийн ашиг сонирхлыг бүс нутагт илэрхийлэх бүтэц юм. 100-150 жилд Оросын нөлөөнд байсан бүс бөгөөд Их Британи, Хаант Оросын хоорондын жийргэвч бүс нутаг байсан.

Төв Азийн улсуудын гадаад бодлогын үндсэн үзэл санаанууд:

- өөрсдийн тусгаар тогтнол, бие даасан байдлаа хадгалан хөгжих
- байгалийн нөөц баялгаа дэлхийн зах зээлд гаргах,
- хил хязгаарын асуудлыг хамтран шийдэх,
- олон улсын тээврийн нэгдсэн сүлжээ үүсгэн түүнд хамрагдах
- Орос, Хятад, Энэтхэг гэсэн томоохон зах зээлд ойр газар зүйн байрлалаа үр ашигтай ашиглах
- бүс нутагт бий болсон олон улсын хамтын ажиллагааны бүтцийг аюулгүй байдлаа бэхжүүлэхэд чиглүүлэх

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Энергетическая геополитика. Китай и Центральная Азия. М.Огугчу /К.Ма/: Sunday, December 30 2007
2. Омаров М.Н. “На повестке дня стратегия России для Центральной Азии”
3. Н.С.Зиядуллаев: Центральная Азия и Шанхайская организация сотрудничества: современные тенденции и перспективы взаимодействия
4. Каримова Г.И. Предпосылки формирования единого энергетического рынка в рамках ШОС – М., Мир перемен, 2005, №4, с. 155